



“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАИГУУЛЛАГА

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо Цэцэзгүн 206 тоот
Утас: (+976) 990965848 (+976) 70001981
И-мэйл: csi_sevjee@yahoo.com

2020. 03.25 20/129.

Танай _____ ны № _____ т

Г “Булган Ундрага” ХК-ийн гүйцэтгэх
захирал Д.Даваадорж танаа

Хараат бус аудиторын тайлан

Дүгнэлт:

Бидний дүгнэлтээр “Булган Ундрага” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу “Булган Ундрага” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд:

Бидний шалгасан тайланд анхаарал татах аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл:

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайландаа гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнаал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм.


Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, няглан бodoх бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох няглан бodoх бүртгэлийн тооцооллыг үнэн зөв, бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.


Аудиторын хүлээх хариуцлага:

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтээр өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэж итгэж байгаач АОУС-ын дагуу хийж гүйцэтгэж байгаа аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ  М.СЭВЖИДМАА



Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо Цэцээ гүн 206 тоот

Утас: 976-70001981,99096584

И-мэйл: csi_sevjee@yahoo.com